



I-V/2022


Тархаасан: 2022 оны 6 дугаар сарын 14



## Экспорт өмнөх сараас 46.2 хувиар өслөө

Монгол Улс 2022 оны эхний 5 сард нийт 142 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 7.2 тэрбум америк доллар, үүнээс экспорт 4.1 тэрбум америк доллар, импорт 3.1 тэрбум америк доллар боллоо. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.3 (21.9%) тэрбум америк доллароор, экспорт 760.8 (22.9%) сая америк доллароор, импорт 535.7 (20.6%) сая америк доллароор тус тус өсжээ. Харин экспорт өмнөх сараас 405.8 (46.2%) сая америк доллароор, импорт 129.3(19.6%) сая америк доллароор тус тус өссөн байна.

ЗУРАГ 1. ЭКСПОРТ, ИМПОРТ, ТЭНЦЭЛ, сараар, сая америк доллароор



Гадаад худалдааны тэнцэл 2022 оны эхний 5 сард 946.5 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 225.1 (31.2%) сая америк доллароор өсжээ. Мөн 2022 оны 5 дугаар сард 496.5 сая америк долларын ашигтай гарч, өмнөх сараас 276.5 (2.3 дахин) сая америк доллароор өссөн байна.

БНХАУ-тай 2022 оны эхний 5 сард 4.4 тэрбум америк долларын худалдааг хийжээ. Энэ нь гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 61.0 хувийг эзэлж байна.

БНХАУ-д экспортолсон бараа бүтээгдэхүүний 44.9 хувийг чулуун нүүрс, 39.8 хувийг зэсийн баяжмал эзэлж байгаа бол Швейцар улсад экспортолсон барааны 99.9 хувийг алт эзэлж байна.

ХҮСНЭГТ 1. ЭКСПОРТ, гол түнш улсаар, жил бүрийн эхний 5 сарын байдлаар

Улс орон	2020 I-V		2021* I-V		2022* I-V	
	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь
<b>Дүн</b>	<b>2 006.3</b>	<b>100.0</b>	<b>3 322.9</b>	<b>100.0</b>	<b>4 083.7</b>	<b>100.0</b>
БНХАУ	1 658.5	82.7	2 998.3	90.2	3 326.9	81.5
Швейцар	157.7	7.9	113.6	3.4	440.5	10.8
Сингапур	70.5	3.5	56.6	1.7	190.1	4.7
ОХУ	21.3	1.1	38.4	1.2	31.1	0.8
БНСУ	6.5	0.3	65.2	2.0	30.2	0.7
Бусад	91.7	4.6	50.8	1.5	64.8	1.6

Экспорт 2022 оны эхний 5 сард өмнөх оны мөн үеэс 760.8 сая америк доллароор өсөхөд нүүрсний экспорт 763.1 сая америк доллароор, зэсийн баяжмалын экспорт 321.4 сая америк доллароор өссөн нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 2. УУЛ УУРХАЙН ГАРАЛТАЙ ЭКСПОРТЫН ГОЛ НЭРИЙН БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН, жил бүрийн эхний 5 сарын байдлаар

Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ		2022* I-V 2021* I-V	Үнийн дүн		2022* I-V 2021* I-V
		2021* I-V	2022* I-V		2021* I-V	2022* I-V	
		сая ам.доллар					
Зэсийн баяжмал	мян.т	491.0	611.2	124.5	1 001.1	1 322.6	132.1
Нүүрс	сая.т	8.9	5.7	64.5	942.0	1 705.1	181.0
Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	т	2.7	7.3	2.7 <sup>1</sup>	162.6	440.0	2.7 <sup>1</sup>
Төмрийн хүдэр, баяжмал	мян.т	3 379.7	1 403.8	41.5	446.4	141.9	31.8
Боловсруулаагүй газрын тос	мян.барр	2 377.8	-	-	136.1	-	-

<sup>1</sup> Дахин их


Нүүрсний хилийн дундаж үнэ сүүлийн 4 сар дараалан өссөн бол боловсруулаагүй газрын тос экспортод гаргаагүй байна.

ЗУРАГ 2. ЭКСПОРТЫН ГОЛ НЭРИЙН БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХИЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, ам.доллароор, сараар

Алт, унци



Нүүрс, тонн




IV	V	VI	VIII	IX	X	XI	XII

I	II	III	IV	V

Зэсийн баяжмал, тонн



Боловсруулаагүй газрын тос, баррель



Экспорт 2022 оны 5 дугаар сард өмнөх сараас 405.8 сая америк доллароор өсөхөд нүүрсний экспорт 251.9 сая америк доллароор өссөн нь голлох нөлөөлжээ.

ЗУРАГ 3. НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН БИЕТ ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН, сараар



2022 оны эхний 5 сарын байдлаар импортын дүнг авч үзэхэд БНХАУ 34.3%, ОХУ 30.5%, Япон 8.3%, БНСУ 4.8%, Америк 3.2%, Герман 2.2 хувийг тус тус эзэлж, нийт импортын 83.4 хувийг бүрдүүлж байна.

ХҮСНЭГТ 3. ИМПОРТ, гол түнш улсаар, жил бүрийн эхний 5 сарын байдлаар

Улс орон	2020 I-IV		2021* I-IV		2022* I-IV	
	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь
<b>Дүн</b>	<b>1 992.4</b>	<b>100.0</b>	<b>2 601.6</b>	<b>100.0</b>	<b>3 137.3</b>	<b>100.0</b>
БНХАУ	676.5	34.0	1 045.0	40.2	1 075.3	34.3
ОХУ	561.3	28.2	670.0	25.8	956.8	30.5
Япон	149.4	7.5	172.5	6.6	261.3	8.3
БНСУ	86.5	4.3	105.2	4.0	151.0	4.8
Америк	120.4	6.0	105.9	4.1	101.3	3.2
Герман	73.7	3.7	103.4	4.0	69.4	2.2
Бусад	324.6	16.3	399.6	15.4	522.2	16.6

ОХУ-аас импортоор оруулсан барааны 57.5 хувийг нефтийн бүтээгдэхүүн, Япон Улсаас импортолсон барааны 68.4 хувийг суудлын автомашин, БНХАУ-аас импортолсон барааны 5.2 хувийг цахилгаан эрчим хүч, 6.3 хувийг ачааны тэрэг, 88.5 хувийг олон нэр төрлийн бага жинтэй, бараа бүтээгдэхүүн эзэлж байна.

Импорт өмнөх оны мөн үеэс 535.7 сая америк доллароор өсөхөд автобензин 136.6 сая америк доллар, дизелийн түлш 84.5 сая америк доллар, суудлын автомашин 68.9 сая америк доллароор тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

**ХҮСНЭГТ 4. ИМПОРТЫН ГОЛ НЭРИЙН БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН, жил бүрийн эхний 5 сарын байдлаар**

Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ		2022* I-V	Үнийн дүн		2022* I-V
		2021* I-V	2022* I-V	2021* I-V	2021* I-V	2022* I-V	2021* I-V
		сая ам.доллар					
Дизелийн түлш	мян.т	404.6	346.7	85.7	207.4	291.9	140.7
Автобензин	мян.т	169.8	275.7	162.4	91.9	228.6	2.5 <sup>1</sup>
Суудлын автомашин	мян.ш	22.6	26.4	117.1	142.3	211.2	148.5
Ачааны автомашин	мян.ш	11.0	8.9	81.4	201.6	98.0	48.6
Цахилгаан эрчим хүч	сая квт.ц	677.9	825.7	121.8	63.1	72.6	115.1

<sup>1</sup> Дахин их

Эрдэс бүтээгдэхүүн, үнэт чулуу, металл, гоёлын зүйлс болон нэхмэл бүтээгдэхүүний экспорт нийт экспортын 98.1 хувийг эзэлж байгаа бол импортын 61.2 хувийг эрдэс бүтээгдэхүүн, машин механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон хүнсний бэлэн бүтээгдэхүүн эзэлж байна.

**ХҮСНЭГТ 5. ЭКСПОРТ, ИМПОРТ, зарим барааны бүлгээр, жил бүрийн эхний 5 сарын байдлаар**

Үзүүлэлт	2020 I-V	2021* I-V	2022* I-V	2022* I-V
	сая ам.доллар			2021* I-V
				хувь
<b>Экспорт</b>	<b>2 006.3</b>	<b>3 322.9</b>	<b>4 083.7</b>	<b>122.9</b>
Эрдэс бүтээгдэхүүн	1 616.8	2 792.9	3 384.9	121.2
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	7.1	43.9	1.9	4.2
Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	4.0	76.3	2.9	3.8
Нэхмэл бүтээгдэхүүн	58.1	137.5	177.5	129.1
Үнэт чулуу, металл, гоёлын зүйлс	265.8	165.4	443.0	2.7 <sup>1</sup>
Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	265.8	162.6	440.0	2.7 <sup>1</sup>
<b>Импорт</b>	<b>1 992.4</b>	<b>2 601.6</b>	<b>3 137.3</b>	<b>120.6</b>
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	163.6	221.4	307.4	138.9
Эрдэс бүтээгдэхүүн	400.9	438.3	677.9	154.7
Үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн зүйлс	183.4	184.3	347.6	188.6
Тээврийн хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд анги	306.8	560.0	439.7	78.5
Хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн	142.1	227.6	223.2	98.1
Хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэл	82.5	96.6	131.7	136.4
Машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл	419.7	460.7	494.7	107.4

<sup>1</sup> - Дахин их

## Ойлголт, тодорхойлолт

**Гадаад худалдааны барааны нийт эргэлт:** Экспорт, импортын нийлбэрээр тодорхойлно.

**Гадаад худалдааны тэнцэл:** Нийт экспортоос импортыг хассан зөрүүгээр тэнцлийг тодорхойлно. Тэнцэл (-) тэмдэгтэй бол алдагдалтай, (+) тэмдэгтэй бол ашигтай гэж үзнэ.

**Импорт:** Улсын материаллаг нөөцийг нэмэгдүүлэн, хилийн чанадаас эдийн засгийн нутаг дэвсгэрт оруулж байгаа барааг тооцно. Нийт импортод гадаадын барааны шууд импорт, дотоодын барааны реимпорт багтана.

**Экспорт:** Улсын материаллаг нөөцийг хорогдуулан, эдийн засгийн нутаг дэвсгэрээс хилийн чанадад гаргаж байгаа барааг тооцно. Нийт экспортод дотоодын барааны шууд экспорт, гадаадын барааны реэкспорт багтана.

**Реимпорт:** Өмнө нь экспортод бүртгэгдсэн дотоодын барааны импортыг ойлгоно.

**Реэкспорт:** Өмнө нь импортод бүртгэгдсэн гадаадын барааны экспортыг ойлгоно.

**Эх орны үйлдвэрлэлийн бараа:** Тухайн улс оронд импортоор оруулж, дахин боловсруулалт хийсэн, үндсэн чанар буюу техникийн шинжийг өөрчилсөн гадаад гаралтай барааг оруулна.



## Эх үүсвэр:

Гаалийн ерөнхий газар

## Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

## Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 7 дугаар сарын 19

Эдийн засгийн статистикийн газрын дарга  
А.Дэмбэрэл  
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын  
статистикч Н.Адъяадорж  
Утас : (976-51)-264797



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212